



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/408

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (23932 га, Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 1 дүгээр багцын гүйцэтгэгчээр шалгарсан "Гранд форест" ХХК-тай 302 500 000 /Гурван зуун хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөр, 2 дугаар багцын гүйцэтгэгчээр шалгарсан "Ойн таксац" ХХК-тай 298 000 000 /Хоёр зуун ерэн найман сая/ төгрөгөөр, 3 дугаар багцын гүйцэтгэгчээр шалгарсан "Мөнх ногоон ой" ХХК-тай 148 290 000 /Нэг зуун дөчин найман сая хоёр зуун ерэн мянга/ төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаварын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Гранд форест" ХХК-ийн захирал (Б.Жавхлантөгс), "Ойн таксац" ХХК-ийн захирал (Д.Баярзориг), "Мөнх ногоон ой" ХХК-ийн захирал (И.Доржжанцан) нарт тус тус даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010383